



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр  
сарын 16-ны өдөр


Дугаар 449

Улаанбаатар  
хот

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн  
авто замын санхүүжилтийн тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөгжлийн банкны тухай хуулийн 8.3.4, 8.3.5, 16.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нүүрсний экспортыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 299 дүгээр тогтоолын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км хүнд даацын, тусгай зориулалтын авто зам, Гашуунсухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалт бүхий дэд бүтцийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн мэдэлд шилжүүлсэнтэй холбоотойгоор тус компанид Хөгжлийн банкнаас олгосон 170.6 (нэг зуун далан тэрбум зургаан зуун сая) тэрбум төгрөгийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт шаардагдах үлдэгдэл хөрөнгийг 2019-2020 оны улсын төсөвт тусгаж эргэн төлөх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Болорт үүрэг болгосугай.
2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан зээлийн эргэн төлөлттэй уялдуулан “Эрдэнэс Монгол” ХХК-д олгосон зээлийн хугацааг сунгахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.
3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замаар бүтээгдэхүүн тээвэрлэх тарифыг тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ ханштай уялдуулан тогтоож, орлого нэмэгдүүлэх арга хэмжээ авч, зам ашиглалтын орлогоос Хөгжлийн банкны зээл, зээлийн хүүгийн төлбөрийн тодорхой хэсгийг төлж барагдуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайханд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Б.БОЛОР